



ГОЛОМТ БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2023 оны 02 сарын 02 өдөр

№ 00/01

Улаанбаатар хот

ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2 дахь заалт, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 02 сарын 02-ны өдрийн ээлжит бус хурлын санал хураалтыг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

- “Голомт банк” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийг олон нийтэд гаргасан нэг бүр нь 250 (хоёр зуун тавы) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 92,463,154 (ерэн хоёр сая дөрвөн зуун жаран гурван мянга нэг зуун тавин дөрөв) ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж нийт 808,657,306 (найман зуун найман сая зургаан зуун тавин долоон мянга гурван зуун зургаа) ширхэг гаргасан энгийн хувьцаатай буюу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 202,164,326,500.00 (хоёр зуун хоёр тэрбум нэг зуун жаран дөрвөн сая гурван зуун хорин зургаан мянга таван зуу) төгрөгөөр тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ГАНБОЛД



GOLOMT BANK
SHAREHOLDER'S MEETING RESOLUTION

Date: 2023.02.02

No. 00/
M

Ulaanbaatar

CONFIRMATION OF SHARE CAPITAL AMOUNT

Pursuant to the Article 29.2.2 of the Banking Law, 31.2, 62.1.15 of the Company Law, voting result of the extraordinary shareholders meeting, it is hereby RESOLVED to

1. The charter capital of Golomt Bank JSC was increased by 92,463,154 (ninety two million four hundred sixty three thousand one hundred fifty four) common shares issued to the public with nominal price of 250 (two hundred and fifty) MNT each and total is 808,657,306 (eight hundred eight million six hundred fifty seven thousand three hundred six) common shares with a nominal price of 250 (two hundred and fifty) MNT each, or a total of 202,164,326,500.00 (two hundred two billion one hundred and sixty four million three hundred and twenty six thousand and five hundred) MNT.

CHAIRMAN OF THE MEETING  G.GANBOLD





ГОЛОМТ БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2023 оны 02 сарын 02 өдөр

№ 00/
02

Улаанбаатар хот

ГОЛОМТ БАНКНЫ ДҮРМИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Голомт банкны дүрмийн 8.2.1 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 02 сарын 02-ны өдрийн ээлжит бус хурлын санал хураалтыг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

- “Голомт банк” ХК-ийн дүрмийг энэхүү шийдвэрийн хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
- Голомт банкны шинэчлэгдсэн дүрмийг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Норихико Като/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ГАНБОЛД



“Голомт банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
хурлын 2023 оны 02 сарын 02-ны өдрийн
00/02 тоот шийдвэрийн хавсралтаар батлав.



ГОЛОМТ БАНКНЫ ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. “Голомт банк” (цаашид “банк” гэх) нь нээлттэй хувьцаат компанийн хэлбэртэй Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж буй банк болно.
- 1.2. Банкны зорилго: Дэлхийн жишиг Монголын банк.
- 1.3. Банкны уриа: Сайн сайхныг санхүүжүүлнэ.
- 1.4. Банкны бүтэн нэр: “Голомт банк” хувьцаат компани (“ХК”).
Товчилсон нэр: Голомт банк.
Англиар: Golomt Bank of Mongolia Joint-Stock Company (“JSC”).
- 1.5. Банкны оршин байгаа газрын хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Д.Сүхбаатарын талбай-5, Голомт банкны төв байр.
- 1.6. Банкны үйл ажиллагааны чиглэл: Банк нь Төв банкнаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр банкны үйл ажиллагаа явуулна. Санхүүгийн бусад төрлийн үйл ажиллагааг хуульд заасан эрх хэмжээ болон хуулийн дагуу авсан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр явуулна.
- 1.7. Банкны хувьцаа эзэмшигчид нь Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу Монгол улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд байж болно.
- 1.8. Банкны хувьцаа эзэмшигч нь банкны өмнөөс хариуцлага хүлээхгүй, түүний үйл ажиллагаатай холбоотой алдагдлыг зөвхөн эзэмшиж буй хувьцааны хэмжээгээр хариуцна. Банк нь хувьцаа эзэмшигчдийн өмнөөс хариуцлага хүлээхгүй.
- 1.9. Банк нь өөрийн хүлээсэн үүргийг зөвхөн өөрийн эд хөрөнгийн хэмжээнд хариуцна. Банк нь төр болон төрийн байгууллагын өрийг хариуцахгүй.
- 1.10. Банкны удирдах байгууллагууд нь Хувьцаа эзэмшигчдийн хурал (“ХЭХ”), Төлөөлөн удирдах зөвлөл (“ТҮЗ”), Гүйцэтгэх захирал (“ГЗ”) болно.
- 1.11. Банк нь Монгол улсын болон гадаад улсын нутаг дэвсгэр дээр Монгол улсын болон тухайн улсын хууль тогтоомжийн хүрээнд өөрийн салбар төлөөлөгчийн газрыг байгуулж ажиллаж болно. Банкны салбар, төлөөлөгчийн газар нь бие даасан хуулийн этгээд болохгүй.
- 1.12. Банк хязгааргүй хугацаагаар үйл ажиллагаа явуулна.

Хоёр. Банкны эрхлэх үйл ажиллагаа

- 2.1. Банк дараах үйл ажиллагааг Төв банкны олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ. Үүнд:
 - 2.1.1. Мөнгөн хадгаламж;
 - 2.1.2. Зээл;
 - 2.1.3. Төлбөр тооцооны үйлчилгээ;
 - 2.1.4. Өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах;
 - 2.1.5. Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;
 - 2.1.6. Үнэт металл, эрдэнийн чулуу худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;
 - 2.1.7. Үнэт зүйл хадгалах;
 - 2.1.8. Гадаад төлбөр тооцоо хийх;
 - 2.1.9. Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах;

GOLOMT BANK
SHAREHOLDER'S MEETING RESOLUTION

Date: 2023.02.02

No 00/02

Ulaanbaatar

APPROVAL OF REVISED BANK CHARTER


Pursuant to the Article 62.1.1 of the Company Law, Clause 8.2.1 of the Bank Charter and decision adopted by the Resolutions during the extraordinary meeting of the Shareholders dated 2th February 2023, it is hereby RESOLVED to:

1. Approve the renewed Golomt Bank JSC charter as per the attachment of this resolution in the Appendix.
2. Assign the duty to obtain the requisite permission and register the amended charter with the State registration office to the Chief Executive Officer /Norihiko Kato/.

CHAIRMAN OF THE MEETING

G.GANBOLD





GOLOMT BANK CHARTER

One. General Provisions

- 1.1. "Golomt Bank" (hereinafter referred to as the "Bank") is established and operating as a Joint-Stock Company in accordance with the laws of Mongolia.
- 1.2. Vision of the Bank: Mongolia's global benchmark bank.
- 1.3. Slogan of the Bank: Committed to and investing in excellence.
- 1.4. Full name of the Bank: "Golomt Bank" Joint-Stock Company ("JSC").
Short name: Golomt Bank.
Name in English: Golomt Bank of Mongolia Joint-Stock Company ("JSC").
- 1.5. The Bank's registered address is Golomt Bank Head Office, D.Sukhbaatar Square - 5, 1st khoro, Chingeltei District, Ulaanbaatar, Mongolia.
- 1.6. The Bank's business activity is to conduct banking operations permitted by the licenses granted by the Central Bank (Bank of Mongolia). Other types of financial activities shall be conducted on the basis of statutory legal powers and licenses obtained in accordance with applicable laws and regulations.
- 1.7. Mongolian or foreign legal entities and citizens may be the Shareholders of the Bank as provided by the laws of Mongolia.
- 1.8. The Shareholder of the Bank shall not be liable on behalf of the Bank, and is responsible for losses related to its activities only to the extent of the shares held. The Bank is not liable on behalf of the shareholders.
- 1.9. The Bank shall be liable for its obligations only to the extent of its assets. The Bank is not responsible for the debts of the government and government organizations.
- 1.10. The governing bodies of the Bank shall be the Shareholders' Meeting ("SM"), Board of Directors ("BoD"), and Chief Executive Officer ("CEO").
- 1.11. The Bank may establish its branch and representative office in the territory of Mongolia and foreign countries within the framework of the laws of Mongolia and the respective country. Bank branch and representative office shall not be considered as an independent legal entity.
- 1.12. The Bank shall operate indefinitely.

Two. Activities of the Bank

- 2.1. On the basis of the licenses granted by the Central Bank, the Bank shall conduct following activities:
 - 2.1.1 Monetary deposits and savings;
 - 2.1.2 Loans;
 - 2.1.3 Payment and settlement services;
 - 2.1.4 Providing guarantees and warranties to third parties on its own behalf;
 - 2.1.5 Purchase, sale, deposit and placing of foreign currencies;
 - 2.1.6 Purchase, sale, deposit and placing of precious metals and jewelry;
 - 2.1.7 Receiving valuables into custody;



ГОЛОМТ БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2023 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 00/03

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 02 сарын 02-ны өдрийн ээлжит бус хурлын санал хураалтыг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан дор дурдсан нэр дэвшигчдийг “Голомт банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр 2023 оны ээлжит Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл хугацаатай сонгосугай.
 - 1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:
 - 1.1.1. Чүлтэм овогтой Мөнхцэцэг;
 - 1.1.2. Жигжид овогтой Үнэнбат;
 - 1.1.3. Шварценбах овогтой Урс Э.;
 - 1.1.4. Лувсандорж овогтой Болормаа ;
 - 1.1.5. Дагва овогтой Мөнхтөр;
 - 1.1.6. Очирпүрэв овогтой Ганжолоо.
 - 1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:
 - 1.2.1. Дваер овогтой Жэймс Б.;
 - 1.2.2. Абэлло овогтой Антонио Л.;
 - 1.2.3. Пикер овогтой Александр;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд холбогдох хууль тогтоомж, банкны дүрэм, компанийн засаглалтай холбоотой журмуудыг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн талаар олон нийтэд мэдээлж, гишүүдийн мэдээллийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /З.Солонго/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г. ГАНБОЛД



GOLOMT BANK SHAREHOLDERS' MEETING RESOLUTION

Date: 02nd February, 2023

No. 00/03

Ulaanbaatar

APPOINTMENT OF BOARD DIRECTORS

On the basis of the Clause 62.1.7 and 77.4 of the Company Law and the decision adopted by the extra-ordinary Shareholders' meeting dated 02nd February, 2023, it is hereby RESOLVED to:

1. Elect the below mentioned Nominee and Independent Directors to the Golomt Bank JSC Board until the Annual General Shareholders' meeting of 2023.

1.1. Nominee Board of Directors:

- 1.1.1. Munkhtsetseg Chultem;
- 1.1.2. Unenbat Jigjid;
- 1.1.3. Urs E. Schwarzenbach;
- 1.1.4. Bolormaa Luvsandorj;
- 1.1.5. Munktur Dagva;
- 1.1.6. Gajoloo Ochirpurev;

1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:

- 1.2.1. James B. Dwyer III;
- 1.2.2. Antonio L. Abello;
- 1.2.3. Alexander Picker;
2. The Board of Directors are assigned the duty to comply with the relevant laws and regulations, the Bank's charter, corporate governance principles.
3. The duty to make the Board of Directors' information public and deliver the information to the Central Bank, Financial Regulatory Commission, Mongolian Stock Exchange to the Secretary of the Board of Directors /Z. Solongo/.

CHAIRMAN OF THE MEETING

G. GANBOLD

